

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

ДОТООД АЛБАН БИЧИГ

Дугаар: 09/14.

Огноо: 2024.04.22

Хаанаас: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс

Хаана: Санхүүгийн хэлтэс болон Бoomt, орон нутаг дахь нэгжийн дарга нарт

Утга: Зөвлөмж хүргүүлэх тухай

Төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн 2024 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын хяналт шалгалтын дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

1. Шилэн дансны цахим [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) хуудсанд мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн тогтоосон хугацаанд тогтол шуурхай мэдээлж, цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;

3. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тушаалтыг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

4. Удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэл, албан даалгавар, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. Төсвийн шууд захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;

6. Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор [jargalmaa.l@immigration.gov.mn](mailto:jargalmaa.l@immigration.gov.mn) хаягаар ирүүлж, үр дүнг тайлагнаж ажиллана уу.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



3.ӨНӨРСАЙХАН